# 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

## БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

- ХҮДРИЙН НӨӨЦ НЭМЭГДҮҮЛНЭ.
- БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО НЭМЭГДҮҮЛНЭ.
- ОН ДАМЖСАН ТАТВАРЫН ӨР ТӨЛБӨРИЙГ БАРАГДУУЛНА.
- ШИНЭ ТӨСЛИЙН ДЭД БҮТЦИЙН АЖЛУУДЫГ ЭХЛҮҮЛНЭ.
- ШИНЭ ТӨСЛҮҮДИЙН ТЕХНОЛОГИ ТУРШИЛТ СУДАЛГААНЫ АЖЛЫГ ЭЦЭСЛЭН ШИЙДВЭРЛЭНЭ.
- ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД 100 МЯНГАН МОД ТАРИНА.
- АЖИЛТНУУДЫН НИЙГМИЙН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭНЭ.

## ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗОРИЛГО

Хаягдлын санд хуримтлагдсан **үүсмэл ордыг** дэвшилтэт технологи ашиглан **дахин боловсруулна**

**Овоот хяр ордыг ашиглах** бэлтгэлийг хангана

Салхит мөнгө-алтны үндсэн ордын **Зүүн хүдрийн биетийг эдийн засгийн эргэлтэд оруулах** бэлтгэл ажлыг хангана

## ҮР АШГИЙН ЗОРИЛГО

| | |
|---|---|
| **188.4** ТЭРБУМ.₮ | НИЙТ ОРЛОГО |
| **26.2** ТЭРБУМ.₮ | ЦЭВЭР АШИГ |
| **22.3** ТЭРБУМ.₮ | УЛСЫН ТӨСӨВТ |
| **42.4** ТЭРБУМ.₮ | ОН ДАМЖСАН ТАТВАР ӨР ШИЙДВЭРЛЭНЭ |

## ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

- ✓ **Овоот хяр** ордыг ашиглалтыг эхлүүлэхтэй холбоотой хөрөнгө оруулалт
- ✓ **Хүрэнцав хайгуулын төслийн** өрөмдлөгийн ажил, лабораторийн ажил, байр зүйн зураглал
- ✓ **Өлзийт овоо хайгуулын төслийн** нарийвчилсан цахилгаан зүсэлт хийх, геотехникийн судалгааны баганат өрөмдлөг. Лабораторийн ажил
- ✓ **Мухар хар толгой хайгуулын төслийн** суваг малталт, сорьцлолт, Лабораторийн ажил

## ХҮРЭХ ҮР ДҮН

| БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | АШИГТ АЖИЛЛАГАА | ЦЭВЭР АШИГ | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | УЛСЫН ТӨСӨВТ |
|---|---|---|---|---|---|
| **188.4** ТЭРБУМ ТӨГ | **154.7** ТЭРБУМ ТӨГ | **18%** | **26.2** ТЭРБУМ ТӨГ | **17.8** ТЭРБУМ ТӨГ | **22.3** ТЭРБУМ ТӨГ |

# 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ

## БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

- ХҮДРИЙН НӨӨЦ НЭМЭГДҮҮЛСЭН
- БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО НЭМЭГДҮҮЛСЭН
- ОН ДАМЖСАН ТАТВАРЫН ӨР ТӨЛБӨРИЙГ БАРАГДУУЛСАН
- ШИНЭ ТӨСЛИЙН БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТУУДЫГ БОЛОВСРУУЛСАН
- ШИНЭ ТӨСЛҮҮДИЙН ТЕХНОЛОГИ ТУРШИЛТ СУДАЛГААНЫ АЖЛЫГ ЭЦЭСЛЭН ШИЙДВЭРЛЭСЭН
- ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД 100 МЯНГАН МОД ТАРЬСАН
- АЖИЛТНУУДЫН НИЙГМИЙН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН

## ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗОРИЛГО

Хаягдлын санд хуримтлагдсан **үүсмэл ордыг** ашиглах хагас үйлдвэрлэлийн технологи туршилт хийгдсэн.

Салхитын **мөнгө-алтны үндсэн ордын** ТЭЗҮ-д тодотгол оруулж ЭБМЗ-өөр хэлэлцүүлж батлуулсан.

Салхитын **Зүүн алт мөнгөний үндсэн ордын** нөөцийг батлуулж, хагас үйлдвэрлэлийн технологи туршилт хийгдсэн.

## ҮР АШГИЙН ЗОРИЛГО

| Төлөвлөгөө | |
|---|---|
| 188.4 ТЭРБУМ.₮ | НИЙТ ОРЛОГО |
| 26.2 ТЭРБУМ.₮ | ЦЭВЭР АШИГ |
| 13.9% | АШИГТ АЖИЛЛАГАА |
| 22.3 ТЭРБУМ.₮ | УЛСЫН ТӨСӨВТ |
| 42.4 ТЭРБУМ.₮ | ОН ДАМЖСАН ТАТВАРЫН ӨР |

## ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

- ✓ **Овоот хяр** ордын нөөцийг тогтоож, нарийвчилсан ТЭЗҮ-г батлуулсан.
- ✓ **Хүрэнцав хайгуулын төслийн** өрөмдлөг, байр зүйн зураглал, лабораторийн ажлыг хийж гүйцэтгэсэн.
- ✓ **Өлзийт овоо хайгуулын төслийн** нарийвчилсан цахилгаан зүсэлт, геотехникийн судалгааны өрөмдлөг, лабораторийн ажлыг хийж гүйцэтгэсэн.
- ✓ **Мухар хар толгой хайгуулын төслийн** суваг малтлат, сорьцлолт, лабораторийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

## ХҮРСЭН ҮР ДҮН

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар*

| НИЙТ ОРЛОГО | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | АШИГТ АЖИЛЛАГАА | ЦЭВЭР АШИГ | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР |
|---|---|---|---|---|---|
| 209.2 ТЭРБУМ ТӨГ | 154.7 ТЭРБУМ ТӨГ | 26% | 54.8 ТЭРБУМ ТӨГ | 15.5 ТЭРБУМ ТӨГ | 75.6 ТЭРБУМ ТӨГ |

# АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА - ХӨДӨЛМӨР АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТ

1,149,504
**хүн цаг**

365
**хоног**

1
**осол дөхсөн тохиолдол**

0
**ҮОХХ**

| ХАБЭА-н зөрчлөөс шалтгаалсан сул зогсолтын хугацаа | Аюултай нөхцөл байдал | Үйлдвэрийн осол, хурц хордлого | Аюултай тохиолдол | Осол дөхсөн тохиолдол | Аюултай үйлдэл |
|---|---|---|---|---|---|
| 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 |

# ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙ

- Байгаль орчны менежментийн 2025 оны төлөвлөгөөний биелэлтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан бүртгэх, тайлагнах журам"-ын дагуу боловсруулж, Дундговь аймгийн Засаг Даргын 2019 оны А/420 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд танилцуулан дүгнүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан бөгөөд **98%-ийн гүйцэтгэлтэйгээр дүгнэгдсэн.**

| Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт | 2020 | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 |
|---|---|---|---|---|---|---|
| Орон нутгийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнээр дүгнүүлсэн хувь, гүйцэтгэл | 90.1% | 91.4% | 92.4% | 100% | 96.8% | 98% |

- 2025 онд Салхит уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөтэй уялдуулан **23,8 га талбайд 388,380.24 м3** уулын цулыг түрж тэгшилсэн бөгөөд хаягдлын овоолго 1, 2-ыг **$11^0$-$16^0$** градус налуужуулж **явцын техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэсэн.**





- Манай компани нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, цөлжилтийг сааруулах, ой, усны нөөцийг хамгаалахад хувь нэмэр оруулах зорилгоор 2025 онд нийт **123,919 модыг тарьсан** бөгөөд тус хөдөлгөөний хүрээнд нийт **564,474 мод бутыг тарьж ургуулж байна.**




- Дундговь аймгийн Сайнцагаан сумын Далай багийн нутаг дэвсгэрт байрлах “Хайрханы ар” нэртэй хууль бусаар ухагдаж эвдрэлд орсон, эзэн холбогдогчгүй байгаа талбайд хэрэгжүүлэхийг санал болгосны дагуу **техникийн нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийж орон нутагт хүлээлгэн өгсөн.**

**2024 ОНД:**

17 ажилтанд **391 сая** төгрөгийн дэмжлэг

**2025 ОНД:**

- 13 ажилтанд **27.5 сая** төгрөгийн орон сууцны урьдчилгааны дэмжлэг,
- 20 ажилтанд орон сууцны зээлийн төлбөрт **13.9 сая** төгрөгийн дэмжлэг
- **2025 онд нийт 33 ажилтанд 634.6 сая** төгрөгийн дэмжлэг үзүүлсэн буюу нийт

**1 тэрбум** төгрөгийг зарцуулаад байна.

Мөн сургалтын төлбөрийн дэмжлэгийг 2025 онд магистрын түвшний сургалтад хамрагдаж буй 2 ажилтанд **10.5 сая** төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

- Орон нутагтай хамтран ажиллах хүрээнд доорх төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр 2025 онд Дундговь аймагт **1.6 тэрбум** төгрөгийг орон нутгийн хөгжлийн санд шилжүүлсэн байна.

| № | Хэрэгжүүлсэн арга хэмжээний жагсаалт |
|---|---|
| 1 | Фасадны засвар (6,7,8-р байр) |
| 2 | Дээврийн засвар (5,9-р байр) |
| 3 | Сайхан-Овоо сумын төвийн камержуулалт |
| 4 | Гурвансайхан сумын төвөөс Мандалговь-Чойр чиглэлийн авто замтай холбогдох 47 км-ын замын зураг төсөв |
| 5 | Шатаах зуухнаас уурын зуух хүртэл шинээр хийх 250мм-ийн дулааны шугамын инженер геологи, геодезийн дэвсгэр зураг, хэмжилтийн зураг төсөв боловсруулах |
| 6 | Сайхан-Овоо сумын усан хангамж ариутгах татуургын шугамын үргэлжлэл ажлын зураг төсөв |

# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХҮРЭЭНД

Бүгд Найрамдах Солонгос Улсын “KIGAM” судалгааны институттэй чухал ашигт малтмалын судалгааны чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг байгууллаа. Энэ үеэр “Эрдэнэс Монгол” ХХК-ийн бүрэлдэхүүн компани болох “Эрдэнэс алт ресурс” ХХК нь “Самсунг” групптэй 17 сая ам.долларын мөнгөний баяжмал нийлүүлэх гэрээг байгуулсан.

**Түүнчлэн Салхитын мөнгөний орд болон уурхайн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор дараах ажлуудыг хэрэгжүүлсэн ба хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:**

**Салхит – Үүсмэл орд**

- Герман-Монголын хамтарсан Ашигт малтмал Технологийн их сургуулийн гүйцэтгэсэн “Флотацийн хаягдлыг дахин ашиглах технологийн судалгааны ажил”-ыг хийж гүйцэтгэсэн.
- БНХАУ дах “Эриез Магнит” ХХК-ийн лабораторид технологи туршилтын ажлыг гүйцэтгүүлсэн.
- Баяжуулах 1 дүгээр үйлдвэрт хаягдлыг боловсруулах 46 цаг, Баяжуулах 2 дугаарт үйлдвэрт 48 цагийн туршилтын ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн.
- Нөөцийн тайлан боловсруулах ажил 90%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна.
- ТЭЗҮ боловсруулах ажил 60%-ийн гүйцэтгэлтэй хийгдэж байна.
- Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ боловсруулах ажил 50%-ийн гүйцэтгэлтэй байна.

**Овоот хяр төсөл – Хойд бүргэд алтны үндсэн орд (MV-022843)**

- Овоот хяр төслийн “Хойд бүргэд” алтны үндсэн ордод 2020 онд хийгдсэн нөөцийн тооцоонд тодотгол оруулах ажлын хүрээнд нэмэлт хайгуулын ажлыг гүйцэтгэж, тодотгол нөөцийн тайланг захын агуулгыг 0.2 гр/тн-оор тооцож Бодитой В зэрэглэлийн исэлдсэн болон анхдагч хүдэрт 48.56 тонн алт, Боломжтой С зэрэглэлийн исэлдсэн болон анхдагч хүдэрт 3.65 тонн алт, нийт В+С зэрэглэл бүхий 52.21 тонн алтны нөөцийг 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батлуулсан.
- Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших MV-022843 тоот Овоот хяр төслийн “Хойд бүргэд” алтны үндсэн ордын нарийвчилсан Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажил 90%-ийн гүйцэтгэлтэй хийгдэж байна.

# ЗӨВ МЕНЕЖМЕНТ - ҮР АШИГ *(2025.12.31-ний өдрийн байдлаар)*

### Уулын цул (мян.м3)




### Хөрс хуулалт (мян.м3)




### Хүдэр олборлолт (мян.тн)




### Үйлдвэрлэсэн баяжмал (тн)




### Баяжмал борлуулалт (тн)




### Борлуулалтын орлого (тэрбум.₮)




### Цэвэр ашиг (тэрбум.₮)




### Улс, орон нутгийн татвар хураамж (тэрбум.₮)

